



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/71/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 70003775, 88883776

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Төлбөрийн акт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ЗГ Засгийн газар

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
З/ТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

ДоА-02-15 № 215

танай _____-ны № _____-т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ч.САРАНГОО ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011020923

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,289,369.15	99,190,732.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,840,581.54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,840,581.54
3121	Төгрөг	-	1,840,581.54
31211	Төрийн сангийн харилцах	-	1,756,420.71
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	84,160.83
33	АВЛАГА	-	52,679,805.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	52,679,805.56
35	БАРАА МАТЕРИАЛ	40,289,369.15	44,670,345.00
351	Түүхий эд материал	10,918,524.90	7,648,471.04
35130	Эм боох материал	10,918,524.90	7,648,471.04
354	Хангамжийн материал	21,814,469.25	27,107,948.96
35410	Бичиг хэргийн материал	455,380.00	462,900.00
35420	Аж ахуйн материал	18,075,789.20	19,994,119.20
35430	Сэлбэг хэрэгсэл	-	556,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,587,979.71
35460	Хүнсний материал	0.05	17,350.05
35470	Бусад хангамжийн материал	3,283,300.00	2,489,600.00
35600	Мал амьтад	7,556,375.00	9,913,925.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	417,272,172.77	403,612,770.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	417,272,172.77	403,612,770.69
392	Биет хөрөнгө	410,704,172.77	397,044,770.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	358,708,185.41	358,708,185.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,664,481.56)	(41,665,551.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,807,360.00	50,220,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,092,383.58)	(10,189,844.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,440,341.06	84,790,891.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,173,666.61)	(54,293,314.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,294,681.00	35,360,571.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,636,071.60)	(25,886,565.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,447,000.00	20,097,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,426,791.35)	(20,097,000.00)
393	Биет бус хөрөнгө	6,568,000.00	6,568,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,568,000.00	6,568,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	457,561,541.92	502,803,502.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,719,960.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,719,960.00
413	Өглөг	-	1,719,960.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,719,960.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	457,561,541.92	501,083,542.80
51	Засгийн газрын хувь оролцоо	457,561,541.92	501,083,542.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	247,055,538.29	247,055,538.29
51101	Өмч: - төрийн	247,055,538.29	247,055,538.29
512	Хуримтлагдсан үр дүн	65,416,948.23	108,938,949.10
51210	Өмнөх үеийн үр дүн	43,788,135.27	65,416,948.23
51220	Тайлант үеийн үр дүн	21,628,812.96	43,522,000.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,089,055.40	145,089,055.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	457,561,541.92	502,803,502.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	403,959,819.00	536,690,510.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,771,956.50	-
120	Нийтлэг татварын бус орлого	65,771,956.50	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,771,956.50	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,771,956.50	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	338,187,862.50	536,690,510.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	292,450,400.00	331,653,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,450,400.00	331,653,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,769,382.50	171,516,240.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,769,382.50	171,516,240.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,320,000.00	16,561,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,320,000.00	16,561,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,648,080.00	16,959,370.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,648,080.00	16,959,370.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	382,331,006.04	536,226,178.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,331,006.04	536,226,178.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,006,518.37	509,524,573.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,106,053.52	311,019,792.02
210101	Үндсэн цалин	199,854,365.52	238,283,514.35
210102	Нэмэгдэл	5,940,407.00	11,026,801.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	418,000.00
210104	Урамшуулал	10,311,281.00	61,291,476.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,708,183.19	43,480,270.16
210201	Тэтгэврийн даатгал	19,138,078.18	32,358,765.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,251,538.61	2,907,115.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,757,550.89	2,282,014.01
210204	Ажилгүйдлийн даатгал	414,637.77	539,306.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,146,377.74	5,393,068.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,294,501.54	12,698,021.79
210301	Гэрэл, цахилгаан	2,537,101.54	3,204,437.23
210302	Түлш, халаалт	13,727,400.00	9,473,584.56
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	20,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,512,707.00	21,550,632.00
210401	Бичиг хэрэг	2,694,708.00	4,281,850.00
210402	Тээвэр, шатахуун	12,136,988.00	10,023,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	773,000.00	766,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,959,365.00	2,575,782.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,948,646.00	3,902,400.00
2105	Нормативд зардал	38,023,521.66	83,693,217.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,011,520.17	72,482,664.78
210502	Хоол, хүнс	7,012,001.50	10,350,552.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	860,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	754,180.50	18,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	754,180.50	-
210604	Урсгал засвар	-	18,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,525,000.00	2,528,000.00
210702	Дотоод албан томилолт	3,525,000.00	2,528,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,022,127.23	-

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,911,249.23	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	690,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210807	Газрын төлбөр	3,378.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,060,243.72	34,536,640.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,438,330.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,621,913.72	34,536,640.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,324,487.67	26,701,605.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,324,487.67	101,605.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,324,487.67	101,605.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,628,812.96	464,331.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,657,463.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,657,463.99
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(5,657,463.99)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,628,812.96	(5,193,132.63)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	247,055,538.29	145,089,055.40	65,416,948.23	457,561,541.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,055,538.29	145,089,055.40	65,416,948.23	457,561,541.92
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,055,538.29	145,089,055.40	65,416,948.23	457,561,541.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,055,538.29	145,089,055.40	65,416,948.23	457,561,541.92
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	43,522,000.87	43,522,000.87
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,055,538.29	145,089,055.40	108,938,949.10	501,083,542.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	338,187,862.50	536,710,210.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	338,187,862.50	536,710,210.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	292,450,400.00	331,653,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,450,400.00	331,653,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,769,382.50	171,535,940.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	19,700.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,769,382.50	171,516,240.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,320,000.00	16,561,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,320,000.00	16,561,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	18,648,080.00	16,959,370.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,648,080.00	16,959,370.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	338,187,862.50	534,869,628.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,187,862.50	534,869,628.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,863,374.83	508,168,023.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,725,536.71	313,808,483.75
210101	Үндсэн цалин	138,688,452.88	163,543,479.00
210102	Нэмэгдэл	58,235,210.00	71,869,870.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,927,000.00	4,355,099.70
210104	Урамшуулал	15,874,873.83	74,040,035.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,088,700.00	43,637,223.99
210201	Тэтгэврийн даатгал	18,420,300.00	30,640,658.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,167,100.00	3,300,518.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,733,700.00	2,640,339.55
210204	Ажилгүйдлийн даатгал	433,400.00	636,433.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,334,200.00	6,419,273.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,251,241.54	16,459,995.00
210301	Гэрэл, цахилгаан	2,537,101.54	3,204,437.23
210302	Түлш, халаалт	10,474,140.00	13,061,557.77
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	194,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,509,939.00	15,396,502.00
210401	Бичиг хэрэг	1,832,410.00	2,132,290.00
210402	Тээвэр, шатахуун	8,815,914.00	7,999,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	773,000.00	818,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,038,515.00	2,045,782.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,050,100.00	2,400,730.00
2105	Нормативд зардал	31,164,599.85	108,287,040.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,541,149.85	99,602,172.92
210502	Хоол, хүнс	5,755,750.00	5,823,567.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	867,700.00	2,861,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,489,180.50	5,100,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,489,180.50	5,100,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,525,000.00	2,528,000.00
210702	Дотоод албан томилолт	3,525,000.00	2,528,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,022,127.23	495,778.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,911,249.23	145,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	690,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	304,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	35,000.00	-
210807	Газрын төлбөр	3,378.00	3,378.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,087,050.00	2,454,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,087,050.00	2,454,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,324,487.67	26,701,605.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	26,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,324,487.67	101,605.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,324,487.67	101,605.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	1,840,581.54
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,840,581.54

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,840,581.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,135,200.00	363,316,244.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,135,200.00	363,316,244.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,135,200.00	363,316,244.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,237,700.00	261,970,212.75
210101	Үндсэн цалин	165,074,000.00	163,543,479.00
210102	Нэмэгдэл	72,451,100.00	71,869,870.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,434,800.00	4,355,099.70
210104	Урамшуулал	22,277,800.00	22,201,764.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,586,800.00	35,461,078.99
210201	Тэтгэврийн даатгал	25,017,200.00	25,017,194.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,642,400.00	2,642,393.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,113,900.00	2,113,837.55
210204	Ажилгүйдлийн даатгал	528,500.00	512,065.87
210205	Эрүүл мэндийн даатгал	5,284,800.00	5,175,587.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,111,100.00	16,459,995.00
210301	Гэрэл, цахилгаан	3,260,000.00	3,204,437.23
210302	Түлш, халаалт	14,611,100.00	13,061,557.77
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	194,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,426,400.00	15,307,502.00
210401	Бичиг хэрэг	2,044,300.00	2,043,290.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	7,999,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	930,000.00	818,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,049,800.00	2,045,782.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,402,300.00	2,400,730.00
2105	Нормативт зардал	24,156,700.00	23,908,377.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,849,700.00	16,840,149.75
210502	Хоол, хүнс	4,207,000.00	4,206,927.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,100,000.00	2,861,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,100,200.00	5,100,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,100,200.00	5,100,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	2,178,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	2,178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,000.00	495,778.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	145,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	304,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,000.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	-
210807	Газрын төлбөр	7,000.00	3,378.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,581,300.00	2,435,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,581,300.00	2,435,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	368,135,200.00	365,072,665.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	333,206,800.00	331,551,695.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	333,206,800.00	331,551,695.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,561,600.00	16,561,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,561,600.00	16,561,600.00

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,366,800.00	16,959,370.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,366,800.00	16,959,370.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,756,420.71
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	23
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	14
620003	Үйлчлэх ажилтан	5	4
620004	Гэрээт ажилтан	4	4

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	171,451,779
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,451,779
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	144,851,779
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,838,271
210104	Урамшуулал	51,838,271
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,176,145
210201	Тэтгэврийн даатгал	5,623,464
210202	Тэтгэмжийн даатгал	658,125
210203	ҮОМШӨ-ний даатгал	526,502
210204	Ажилгүйдлийн даатгал	124,368
210205	Эрүүл мэндийн даатгал	1,243,686
2104	Хангамж, бараа материалын зардал	89,000
210401	Бичиг хэрэг	89,000
2105	Нормативт зардал	84,378,663
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,762,023
210502	Хоол, хүнс	1,616,640
2107	Томилолт, зочны зардал	350,000
210702	Дотоод албан томилолт	350,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,700
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,600,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,600,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,600,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	171,535,940
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,535,940
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	19,700
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	171,516,240
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,161

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор О.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь: Эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 536,226.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,043.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,032.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 44,670.3 мянган төгрөг болж 4,381.0 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 555,745 мянган төгрөг болж 7,520.5 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь орон нутаг хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хүлээн авсан 9,500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 10,850.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,184.4 мянган төгрөгийн тавилга эд хогшлоор нэмэгдэн, акталсан 34,055.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр хасагдсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 181,446.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө болон бараа материал болон орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 153,895.1 мянган төгрөгөөр өссөн нь бараа үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 368,135.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 368,135.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 368,135.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 349,768.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 18,366.8 мянган төгрөгийг хандив тусламжийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 348,214.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 16,959.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 364,174.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 363,316.2 мянган төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд төрийн сангийн харилцах дансанд 1,756.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт 101.6 мянган төгрөг буюу 0.5 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөлөнбуйр сумын дээд шатны төсвийн захирагчаас 171,516.2 мянган төгрөг, хандив тусламжийн орлогоос 19.7 мянган төгрөг, нийт 171,535.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 19.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 26,600.0 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 350.0 мянган төгрөг, нормативд зардалд 84,378.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 89.0 мянган төгрөг, цалин урамшууллын зардалд 60,014.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос тус тус зарцуулж, нэмэлт санхүүжилтийн дансанд 84.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 120.5 сая төгрөгийн 12 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд 9 мэдээллийг бүрэн мэдээлж, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрлэлтэд хамрагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81,325.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,640.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,091.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 53,593.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Машин тоног төхөөрөмжийн нэмэгдсэн 7,450.2 мянган төгрөгийн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан, ерөнхий журналын дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдсэн;
2. Цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлэн авлагаар бүртгэсэн байна;
3. ЭМГ-аас үнэ төлбөргүй ирсэн 14,098.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн тайланд тусгаагүй байгааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд 3,091.6 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлагаар бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.4 “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг зөрчсөн байна.

4.3 Төлбөрийн акт

1. Эм эмнэлгийн хэрэгслийг бараа материалын тайлангаар орлого авахгүй шууд зардалд 8,889.6 мянган төгрөгийн бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө, 26.2-т Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв ба бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант онд 44,703.8 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил,

үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв	7	81.3	3	24.6	1	3.1	3	53.6	-	-